

ЧИНГИС ХААНЫ БАЙЛДАН ДАГУУЛАЛТАНД МОНГОЛ МОРИНЫ ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

Г.Сэр-Од
Тэнгэр Дээд сургууль

Өгүүлэлийн товч утга: Нүүдлийн амьдралын хэв маяг давамгайлсан Монгол түмний итгэлт нөхөр бол хүлэг морь билээ. XII-XIII зууны талын Монголчууд морин нуруун дээр төрж, морин нуруун дээр амьдарч, мөн морин нуруун дээр хорвоогийн мөнх бусыг үзүүлж байсан байсан амой. Морь бол Их Монгол улс байгуулагдах үйл явц, ер нь монголчуудын байлдан дагуулалд хамгийн онцгой үүргийг итгэлтэйгээр үзүүлж байснаар ахуй амьдрал, аян дайны үнэлж баршгүй хувь нэмэр оруулжээ.

Түлхүүр үгс : Монгол морь, адууны өвөг, морины тэсвэр тэвчээр, байлдан дагуулал, тоног хэрэгслэл

Дээд тэнгэрээс заяатай гэгдэх бидний Монголчууд агт морь, аргамаг хүлгээ төрийн сүлдэндээ дээдэлж онголсон дэлхийд ганц биш юм гэхэд адуун сүрэг, агт морьд ажнай хүлгээ магтан дуулсан дуу хөгжим, шүлэг найраглал, мөнхлөн үзүүлсэн кино, үлгэр домог, зураг сийлбэр, судар ном хэдэн зуун арвыг туурьвиж сүмбэлсэн язгуур соёлт, тэнгэрлиг түмэн бүлгээ.

Хүн төрөлхтөн зэрэг амьтдыг гаршуулан малладаг болсон цагаас эхлэн адуу хүмүүсийн аж амьдралд нь уналга, тээврийн чухал үүргийг гүйцэтгэж эхэлсэн бөгөөд улмаар аян дайн болон ахуй амьдралын үйлс нь тухайн цагт түүнгүйгээр бүтнэ гэж сэтгэхийн ч хэрэггүй юм.

Төв Азийн нүүдэлчин аймгууд зэрлэг амьтдыг анх барин авч, МАА-г эрхлэн амьдарч ирсэн нь тэдний нийгмийн үйлдвэрлэх хүчний хөгжилд шууд нөлөөлжээ. Хүн төрөлхтний түүхэнд гүн ул мөрөө үлдээсэн Монгол туургатаны амьдрал үйлс нь уламжлалт аж ахуйтайгаа, түүний дотроос адуун сүрэгтэй салшгүй холбоотойг Монголын түүхийн тулгуур бичгүүдэд өгүүлсэн нь арвин болой. МНТ-г уншин үзвээс, МАА-н холбоотой баримт сэлт, уран дүрслэл тэргүүтэн ямагт сонирхол татдаг.

Монгол морины гарал, үүслээс: Монгол улс нь өнөөгийн байдлаар нэг хүнд ноогдох адуугаараа дэлхийд тэргүүн байранд заларч, адууныхаа тоогоор гуравт бичигдэж буй. Энэ хүчит хүлгийн гарал үүслийг олон судлаачид судалж бүтээл, туурвил арвин бичжээ.

“Төв Азийн нутагт оршин суурьшиж, мал аж ахуй, ан гөрөө эрхлэн амьдарч байсан монголчууд, түүний сайн нөхөр, үнэнч туслах болох Монгол адууны тухай

сонирхож буй сэдвээ чиглэлийн зохиол бүтээлүүд болон баримт сэлтэд анхаарлаа хандуулсан” (1) билээ.

“Монгол адуу дэлхийн адууны өндөр өвөг-Эогиппусээс гарвал авч Төв Ази дахь ойрын зэрлэг өвөг тахиас үүсч хөгжсөн филогенезийн түүхэн уламжлалтай.

Шинэ чулуун зэвсэгтний үед өөрөөр хэлбэл найман жилийн тэртээ Төв Азид адгуус амьтдыг гарын мал олгож гэршүүлэх ажил ирмүүн явагдсан байна. ...Иймээс Монголд үүсч хөгжсөн эдүгээгийн бэлчээрийн мал аж ахуй түүний дотроос адуун сүргийг дунджаар 4500-5000 орчим жилийн түүхтэй гэж нийтээр хүлээн зөвшөөрдөг...” (2) хэмээн Монгол адууны түүхийг товчоолжээ.

Харин манай түүхчид адууны үүслийг арай өөрөөр өгүүлсэн байдаг. Одоо түүхийн шинжлэх ухааны үүднээс уг асуудалд анхаарл хандуулая. Монголын нэрт түүхч Г.Сүхбаатар: “МЭӨ-Х зууны үед холбогдох морины хүрэл хөрөг нь Монгол морьтой адил”/ 3 / хэмээжээ.

Эртний судлаач, зэвсгийн түүхийг товчоологчдын номонд Ноён уул, Хүнүй гол, Наймаа толгой, Дуулга уул, Сэлбэ голын Бэл гэх газраас олдсон төмөрлөг эд хэрэгслэл, дөрөө, хазаарын амгай мэт төмөр урлалын олдворууд олдсон болохыг өгүүлжээ. Энэ нь цаг хугацааны хувьд 3000 орчим жилийн мал аж ахуй тэр дундаа адууг сонгодог утгаар нь өсгөн үржүүлж, иргэний болон цэрэг дайны үйлд өргөнөөр ашиглах болжээ. Түүхийн зохиолд: “... МЭӨ VIII-V зууны үед Хятад хүмүүс морь унаж, эдэлдэггүй байсан учраас хазаарын төмөр амгайг огт мэддэггүй байжээ. Үүнээс бүр хойно хүннүгээс морь (адуу) авч унах, эдлэхийг хүннүчүүдээр заалгасаны сүүлээр сая хазаарыг мэддэг болсон” (4) гэсэн нь талын нүүдэлчид суурин иргэншил төлөвшсөн Хятад иргэнд адууны аж ахуйн анхны ухагдахуунд сургаж өгчээ.

Өөрөөр хэлбэл, эрт цагт Хятадын улсууд ар газрын нүүдэлчдээс адуу түүнд холбоогдох тоног хэрэгслэлд хорхойсон шунаж, тэднээс өгөхийг шаардаж байжээ. Судлаачид энэ талаар “Хан улсын хаан У Ди бээр Ферган/ Давань/-ы баялаг, түүний “жигүүртэй” морьдыг худалдан авах зарлиг буулгасан байна. Гэтэл Ферганы засгийн газар Хятадад морь гаргахыг хоригложээ” (5) гэжээ.

Дээр өгүүлсэн баримтаас авч хэлбэл, Азийн төв хэсэгт монгол агт нь 5000 жилийн тэртээ анх үүсээд, түүнийг тал нутгийн нүүдэлчид гаршуулан ашиглаж

сурсанаас гадна хөрш зэргэлдээ аймаг, улсдаа адуу маллагааны арга маягаа заан хөгжүүлж байсан нь илэрхий байна.

Монгол морины өсөлт, тэсвэр тэвчээр: Монгол морьдын тэсвэр тэвчээрийн талаархи анхны мэдээ баримт Хүннүчүүдийг үетэй холбоотой байдаг. Тухайлбал, Оросын нэрт эрдэмтэн В.С.Таскин нанхиад сурвалж мэдээг нягтлан үзээд “...Хүннүгийн хөнгөн зэвсэгтэй морин цэрэг нэг хоногт 159-212 км газар явдаг” (6) гэсэн нь “... монгол морьд өдөрт 100-120 миль (1 миль 1609 м-тэй тэнцэнэ) явдаг байдаг юм” (7) гэж бичсэнтэй тийм ч хол зөрүүгүй байгаа нь Монгол морьдын туулах чадварыг тогтооход чухал юм.

Монголын Нууц Товчооны 245 зүйлд “*Чингис хааны агтны хорооноос ч олон хүн Тэв тэнгэрт очиж захирагдав*” (8) гэж өгүүлсэн байхаас гадна цэргийн агт морьдыг сүрэг болгон маллах бэлтгэл нөөц сүрэг байгуулж, морийг унаж сургах, цэрэг дайны зориулалтаар бэлтгэх ажлуудыг хийж байв. Чухам энэ үеэс адууг агуулж маллах, сургах ажилд “*адуучин*” гэх мэргэшсэн хүнийг анх түүхэнд тэмдэглэсэн байдаг.

Ийнхүү адуу, морийг багаас нь уналга, өртөө улаад бэлтгэн хэрэглэхээс гадна ан хомрогонд ашиглах, ан агнах нь нэг ёсны хүн, морио дайн тулаанд дадлагажуулах сургууль болдог юм. Үүний хамгийн тохиромжтой нутаг нь Монголын тал нутаг ажээ. Учир нь Хятадын судлаачдын бүтээлд Монголчуудын орчин ахуй нь мал хариулан өсгөхөд хамгийн тохиромжтой нутаг болохыг заан өгсөн байдаг билээ.

Гадаадын судлаачид монгол морины бие бялдарын талаар: “...Түүний (Монголчуудын.Г.С.) морь нь намхан, нуруугаараа 130 см орчим, хурд жин хоёроорос иргэншсэн орны морьдоос дутах боловч тэсвэр тэвчээрээ тэдгээрээс хол давдаг” (9) гэж бичсэн байдаг. Манай судлаачид адууныхаа өслтийн тухай: “Монгол морины бие бялдар нь сайн байдаг. Учир нь Монголчууд хүлэг унааныхаа зориг чадлыг илэрхэмлэдэг. Эмнэг морийг анх унаж сургахдаа яавч тамир тэнхээг нь барагдтал унадаггүй. Харин хүчин чадлыг нь төгөлдөржин цог сүлд нь бадарч мориноосоо бууж биеийг нь амс хийлгэж хүчин чадал, цог сүлдийг нь нэмэгдүүлэхийг хичээдэг” (10) нь адууныхаа өсөлтийг ихээхэн анхаарч байсны гэрч болно.

Монголчуудын уламжлалт хүлэг морио сургах заншил ёсны хамгийн боловсронгуй хөгжсөн нэг онцлог бол түүнийгээ нялх багаас нь цөс зоригийг нь хатуужуулах явдал болно. Тал нутаг маань өргөн уудам агсан тул мориндоо

мордмогцоо л хэдэн бээр газар давхих учир хэзээ ч гардаг. Өвөг дээдсүүд маань “эмнэг морийг сургахдаа унаа морио чадал хүчийг нь жишин, хүч чадал нь буурахаас өмнө бууж хүчин чадал сүлд нь бүр мөсөн сэргэмэгц дахин морддог (сургадаг.Г.С.). Энэ мэтээр аажим сөс зоригийг бүрэлдүүлж, хүчийг нь тэжээн, итгэлийг нь нэмэгдүүлдэг. Монгол морьд багаасаа хүчээ шавхаж зоригоо мохоож үзсэнгүй болохоор унасан эзнээ урагш тэмүүлдэг л байвал цог сүлд нь улам нэмэгдээд, ид хүч нь нэн ороод давж гарч, дайран шувтлах итгэл сөсийг хөвчлөөд л байдаг” (11) хэмээн С.Сампилноров номондоо бичсэн байна. Ийн өгүүлсэнээр монголчууд хүлэг мориныхоо тэсвэр тэвчээр, зориг зүрхийг удаан хугацаанд тодорхой үе шаттай нарийн хэрэгжүүлсний үндсэн дээр 70 орчим мод газар саадгүй хурдлах сэтгэлийн хүчийг тогтоон барих ажээ. Энэ мэтээр морины яс чанар хатуурч, нас нь нэмэгдэх тусам цог сүлд нь жигдрэн, мохошгүй тэсвэр тэвчээр нь хуримтлагддаг байна.

Чингис хааны цэргийн байлданы чадвар-чадавхи нь зэвлэх морьдынх нь эрдэм чадвар, чанараас ихээхэн шалтгаалж байжээ. Монгол морьдоос өөр ямар ч адгуус байсансан бол тусгайлан бэлтгэсэн өвс тэжээлгүйгээр нуруун дээрээ хуяг дуулгатай цэрэг эрс, тэдний бүхий л зэр зэвсэг, хоол хүнсийг тээн түмэн зовлон, мянган бэрхтэй холын аянд тээвэрлээд зогсохгүй хэдийд ч байлдаанд бэлэн байх тухай санахын ч хэрэггүй юм.

Цэргийн түүхч, доктор Х.Шагдар энэ талаар, “Монголчууд даагыг сургаж унаад 3 жил хур тавьсны дараа уналгад оруулж байлдаанд сургана. Зэвлэх морьд нь цаламдах, дэгээдэх зэрэгт эзний хамт зүтгэж сурсан, тулалдааны их чимээнээс үргэж бусгахгүй болсон байх ёстой. Харанхуй шөнө эзэндээ нүд болно, харийн чимээ сонсож чих болно” (12) гэж монгол морины тэсвэр тэвчээр, дайны үед биеэ хэрхэн зохицуулж байсан талаар өгүүлжээ.

Мөн тэрээр цааш өгүүлэхдээ: “Дайнд унадаг морийг хавар бэлчээрт тавиад унахыг цаазална. Өрнийн салхи ирэх үед гаднаас барьж уяад бага сага өвс өгнө. Сар өнгөрсний дараа тарга хүч буурч, чангарсан хойно хэдэн зуун газар унавч хөлс гарахгүй” (13) гэж бичжээ. Монголч эрдэмтэн Лео Де Хартог номондоо: “Монголын морин цэргүүд морин дээрээ үлэмж хэмжээний зэр зэвсэг агсаж явдаг байжээ. Хоёр нум, гурван саадаг нум- мадага хэмээх хадуур хэлбэртэй жад мөн адага хэмээх дэгээг ардаа авч явдаг байсан нь дайснаа мориноос нь татан унагах зориулалттай

байжээ” (14) гэх мэтээр бичсэн байгаа нь Монгол морины бууршгүй хүчийг илтгэх ажгуу.

Монгол үндэстэн бол “морьт үндэстэн, морин нуруун дээрхи үндэстэн” гэж түүхэнд алдаршсан нь хоосон мандсан нэр биш ээ. Монголчууд морь уралдах, морин уралдаж, морин мөрийцэхийг аль эртнээс өөрийн тамирын хөдөлгөөн ба уралдаан тэмцээний нэг агуулга болцгоосон байдаг. “Юань улсын судар”-т уламжлагсанаар: “Монгол үндэстэн умард газар үүсч, морь уралдах үед их дуртай. Ялангуяа нум тэлэхээр ихэд гайхуулж, дэлхий дахинд алдаршжухуй. Юань улс умард газраас үүсч, оролдох, намнах, ...элсэн далайдаа дуртай байж өнөр баялаг мал адгуулан, зарц боолын морьдын тоог бараглахгүй бэрх байж нэгэн үе мандсан билээ” (15) морь маллагааны талаар өгүүлэх авч цаад мөн чанар нь Монгол Юань улсын үеийн морио өсгөн үржүүлж, дадлагажуулан сургаж байсан түүхийг илэрхийлэхийг зорьжээ.

Мөн “Монголчууд XIII зуунд мориныхоо хуягыг хатуу, зөөлөн арьс шир, эсгий зэрэг эдээр хийдэг, түүний хуяг таван хэсгээс бүрддэг. Сүүлнээс аваад толгой хүртэл биеийн хоёр хажуугаар тус тус нэжгээд хамгаалалт хийх бөгөөд эмээлтэй холбон тогтооно. Хөндлөн нурууны хамгаалалтад нүх гаргаж, түүгээр морины сүүлийг гаргана. Бас цээж, хэнхдэгийг хамгаалсан байдаг. Эд бүгд доош өвдөг, эсвэл шилбэ хүртэл унжина. Морины магнийн тус газар зураас төмөр халхавч хийж, хүзүүний хоёр талаар явуулан дээрхи хамгаалалттай холбон тогтоодог байв” (16) гэж эрдэмт хүлгээ дайн, тулааны үед эрсдүүлэхээс ихэд болгоомжлон хамгаалдаг байжээ.

Чингис хааны байлдан дагуулалд Монгол морины гүйцэтгэсэн үүрэг: Бидний Монголчуудын эртний өвөг болох Хүн нар анх 2000 гаруй жилийн өмнө Төв Азийг байлдан дагуулж, Монгол нутагт анхны төр улсын тугийг тахижээ. Тэдний үйл хэргийг залгамжлагч болон мандсан олон улсууд тэдгээрийг удирдаж байсан хаадууд цэрэг-улс төр, шуудан холбоо, өртөө улаа, гааль татварын хатуу чанга суурь бодлогыг залгуулж, хэрэгжүүлэгч хүч нь Их хаад түүний гарамгай жанжнууд хийгээд цэрэг эрсийн хамгийн дотны нөхөр-үнэнч туслагч бол агт морь болой. Гэсэн хэдий ч энэ талын шинжлэх ухааны судалгаа төдийлөн хийгдээгүй удсаар Монгол судлалын нэгэн сонирхолтой агаад нэн чухал сэдэв бүтээгч эрдэмтнийхээ оюун ухааны далайцаар мэндлэх цаг үеэ хүлээсээр л амой.

Чухамдаа тал нутгийн нүүдэлчдийн байгуулсан анхны эзэнт улс Хүннүгийн үед бүр цаашлаад эсгий туургатны амьдрал, тэмцэлийн уртын урт аянд “морь” бол нүүдлийн аж ахуй, нүүдэлчдийн амьдрал, тэдний төр гүрний аюулгүй байдал-тусгаар тогтнолоо баталгаажуулахад үлэмж үүрэг гүйцэтгэж ирсэн монголчуудын оюуны билэг тэмдэг бүлгээ.

Богд Чингис хааны байгуулсан Их Монгол Улсын хил хязгаар нь “Монгол Алтайн нурууны баруун бэл хормой, Эрчис мөрний хөндий, зүүн хил нь Их Хянганы нуруу өнгөрч байсан бол хойд хязгаар нь өмнөд Сибирь, Байгал нуур, зүүн баруун Соёны нуруугаар оршиж... (17) байсан бөгөөд түүнийг залгамжлагчдын байлдан дагуулалын үр дүнд улам өргөжин “одоогийн Оросын Холбооны Улсын дорнод хил буюу Номхон далайгаас тэртээ баруун зүгт Дундад Ази бүхэлдээ цааш хальж Кавказын нуруу Каспын тэнгисээс хэтэрч Хар тэнгист тулан Газар Дундад тэнгисийн зүүн эрэг хүрч, тэндээсээ урагш Персийн булан хүрсэн агаад зүүн тийшээ өнөөгийн Энэтхэгийн уулархаг хойд хэсгийг давж, Түвэдийн цас уулыг багтаан алдарт Гималайн нурууны хормой дайрч хамгийн өмнөд зах нь өнөөгийн Вьетнамын нутгийн өмнөд хил, Дорнод хятадын тэнгисийн баруун өмнөд эрэгт хүрчээ” (18). Энэхүү агуу агуу уудам нутагт Монгол баатруудын уухайлах дуун тэнгэрт эгшиглэж, монгол морьдын хүчит дөрвөн туурай дэлхийн талыг тамгалан, хүн төрөлхтний иргэншилт амьдралд бараг дахин давтагдашгүй, эгнэн харьцууламгүй түүхэн үйл явц тэртээ найман зууны өмнө болсон ч өнөө хэр тэнгэрийн доорхийг сэртхийлгэсээр, өнөө цагт доорд үр ач нар нь шагшин бахархавч баршгүй ажээ.

Дэлхийн олон үндэстэн угсаатныг нэгтгэсэн дээр өгүүлсэн уудам нутгаар ноёрхолоо тогтоох явцдаа механикжсан техникийн оронд Монгол морийг голлон хэрэглэсэн нь түүхийн баримт мэдээнд тодорхой тэмдэглэгджээ. Чингис хааны уг эх болох, Монголын Нууц Товчоонд малын гаралтай нэр тэмдэглэгдсэний 70 орчим хувийг адуун сүрэг-монгол морьтой холбоотой байдгаас харахад “Морь”- нь их хааны байлдан дагуулалтын гол уналга, бас ялалтын үр дүнгийн артерийн судас нь болж байв. Чингис хаан байлдан дагуулалаа анх эхлэхэд Монголын хүн ам барагцаагаар нэг сая орчим, цэрэг нь хорин түм нэг цэрэг хөтөлгөө морь эзэмшиж байсныг бодоход агт морины асуудал төрийн хэмжээний том бодлогод дэмжигдэн хэрэглэгдэж байсан нь гарцаагүй бөлгөө.

Чингис хаан түүний залгамжлагчдын дэлхийг тойрсон аян дайн, түүний ялалт амжилтанд Монгол морьдын оруулсан хувь нэмэр асар их бөгөөд зэвлэх морьдгүйгээр өөр ямар ч сайн зэвсэгтэй байлаа гээд дэлхийд өмнө нь байгаагүй хойшид ч бий болох нь үлгэр мэт тийм аугаа эзэнт гүрний сүр жавхааг илтгэхийн аргагүй болой.

Европын судлаач С.С.Уолкерийн номонд “ Монголчуудын дайн байлдааныг ойлгохын тулд юуны өмнө хүмүүсийг, энэ хүмүүсийг нуруун дээрээ мордуулсан адгуусан амьтан (морь.Г.С)-ыг ч судлах хэрэгтэй ” (19) гэж ончтой тэмдэглэсэн буй.

“Эртний монголчуудын хувьд дайн байлдааны хамгийн чухал хэрэгслэл нь зэвлэх морин цэрэг байв. Агт морьд суурин иргэншилд давамгайлсан улс орны цэрэг дайчдад алхам дутам шаардагддаггүй зүйлийн нэг байсан бол нүүдэлчин Монгол түмний хувьд дээл хувцас шиг амьдралын хэрэгцээ, заавал байх ёстой ердийн хэрэгслэлийн нэг байжээ” (20) гэж цэргийн түүхч Ж.Базарсүрэн өгүүлжээ..

“Адууг бусад малаас илүү ихээр хэрэглэж, төрийн бодлого болгон үржүүлж байсан тухай ... олон мэдээ сэлт эртний сурвалж бичигт элбэг байдаг” (21) бөгөөд тухайлбал Нууц Товчооны 199-р бүлэгт мэргэдийн үлдэгдэлийг нэхэн устгах үүргийг Чингис хаан Сүбээдэй жанжиндаа зарлиглан тушаахдаа: “Газрын холыг бодож цэргийн улаа (морьд.Г.С)-гаа тураагүйд нь хайрлагтүн. Хүнсээ дуусаагүйд нь гамнагтүн. Агт нэгэнт турж дуусвал хайрлаад ашиг үл болно. Хазаар үл нөмөргөн амгайвчлаж явтугай. Тийн журмыг журамлаж явбаас цэргийн хүн уулгалан (давхиж) давхиж хэрхэн чадна? ” (22) гэжээ. Их хааны энэ айлдвараас үзэхүл, бидний өвөг дээдэс маань адуу малаа хайрлан хамгаалж үр шимийг нь хүртэж байснаас гадна ажил үүргээ **хүн-байгал-амьтан** гэх гурамсан харилцааны шүтэлцээнд авч, төрийн хэмжээнд хэрэглэж байсан нь амжилтанд хүрэхийн нэгэн уг сурвалж байлаа.

Чингис хааны байлдан дагуулалын тухай хүүрнэхдээ Хятадын эрдэмтэн Сайшаалын судалгааг дурьдалгүй өнгөрч боломгүй билээ. Тэрээр удаан хугацаанд сайхь хүмүүний намтар товчооныг судлаад бичсэн нэгэн дорвилог бүтээлдээ бидний өгүүлж буй асуудлын талаар: “ Морь бол морьт цэргийн амьд зэвсэг болох бөгөөд XIII зууны үед зам харилцааны хамгийн хурдан багаж хэрэгслэл болж байснаас гадна чухалтай үед амь гол залгах хүнс ч болдог байв” (23) хэмээсэн нь адууны үүргийг өндрөөр үнэлсэн чухал дүгнэлт болно.

Мөн С.С.Уолкер өөрийн номдоо: *"Хаврын анхны ногоо цухуйнгуут тэрбээр маш хурдан тэвээрэг авна. Зайлшгүй шаардлага юм бол Монгол адуу ус, тэжээл туйлын бага хэрэглэн дээд зэргийн хол замыг туулах чадвартай. Харин Монголын морьт отрядууд 150 орчим миль газрыг ихэвчлэн гурван өдрийн дотоор туулаад барахгүй аялалаасаа шууд л тулалдаанд ордог байжээ. Хэрэв Чингис хаан ба түүний залгамжлагчдын гарт хэрэгтэй өдөрт 60-80 миль газрыг туулж, заримдаа эзэндээ өөрийн цусаа өгдөг, жижиг биетэй, тэсвэр тэвчээртэй Монгол морь шиг байлдааны тийм сайн хүчирхэг зэвсэг олоогүй бол тэд асар уудам газар нутаг дээр засаглал, нөлөөгөө тогтоож чадах байсан эсэхийг хэн мэдлээ"* (24) гэж бичсэн байна.

Чингис хаан өөрийн амьдран буй цаг үеийнхээ цэргийн шинэчлэл хийхдээ явган цэргээс илүүтэй морин цэрэгтээ хамаг найдлагаа хандуулж, мөнхүү инженерийн ухаанд суралцсан тусгай хороог цэрэгтээ дагалдуулан явуулдаг байжээ. Энэ тухай АНУ-ын монголч эрдэмтэн Жек Ведерфорд: *"Монгол цэрэг бүр доод тал нь таван морьтой, морио амархан сольдог бөгөөд зүсээр нь сайн ялган таньдаг, огт нэр өгдөггүй байв. ...морио хуягладаггүй учир хөнгөн хурдан давхиж Монгол морьт цэрэг тулааны талбарт ямагт ялалт байгуулж явсан юм"* (25) гэжээ.

Өмнө хэдэнтээ дурьдсан зэвлэх морьдыг орчин үеийн цэрэг-армийн механикжсан хэрэгслүүдтэй дүйцүүлэн үзэх нь бий. Тодруулбал: *"Зэвлэх морьд нь одоогийн цэргийн авто, хуягт танкийн техник, нисэх онгоц лугаа адил дундад эртний Монголын цэргийн байлдах аргын үндэс маневр тактикийг хэрэгжүүлэхэд гол хүчин зүйл болж өгчээ"* (26) гэх мэт.

Хятадын судлаач Сюй Да Хень "Монголын зан суртахуун" гэх бүтээлдээ: *"Монгол хүн энгийн үед ч морь унахаар барахгүй бачим үед бас морь унаж, ан агнахад ч бас морь унадаг. Монголчуудын сайн хань, дотны нөхөр нь морь ..."* (27) хэмээсэн бол *"Хүн мал хоёрын хоорон дахь ийм хүчирхэг холбоог дараа дараагийн зуунуудад Азийн өнгө төрхийг тодорхойлсон Монгол морин цэрэг шиг дайн байлдааны тийм чухал хүчин зүйлийг соёл иргэншил хэзээ ч бий болгож чадаагүй гэдгийг тодорхой хэлэх байна"* (28) хэмээн судлаач С.С. Уолкер дуу алдан өгүүлсэн байдаг бөлгөө.

Монголчуудын морь ба түүний тоног хэрэгслэл зэвсгийн чанартай хэрэглэгдсээр ирсэн юм. Жижиг боловч чийраг монгол адуу нь хүнс хоол болж

айрагаар хангахын дээр өл дааж, урт удаан аян хийх унаа тээврийн хэрэгслэл байлдааны талбарт түргэн маневрлахын гайхамшигийг үзүүлэх зэвсэг болж байлаа. Тийм учраас Монголын хаад, ноёд доорхи хүмүүстээ *"морио бүү алдагтүн"* (29) гэсэн зарлиг тархааж, зарж үрэхийг хориглож байсан баримт эртний сурвалж бичгүүдэд дэлгэр тэмдэглэжээ.

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд, Тал нутгийн нүүдэлчин Монголчууд бол адууг өсгөн үржүүлэх, сургахын зэрэгцээ түүнийг аж ахуй болон дайны үйлд хэрэглэх бүхэл бүтэн дэг сургуулийг бий болгоод зогсоогүй түүхийн урт удаан хугацааны эргэлтэнд түүнийгээ улам боловсронгуй хөгжүүлж, аж амьдрал, соёл-гоо зүйн биеэ даасан шинжлэх ухааныг бий болгосон тэнгэрлиг заяат түмэн бөлгөө.

Хүн төрөлхтний соёлын санд нүүдэлчидийн оруулсан МАА-тай аян дайны болон ахуйн хэрэгцээний зүйл бол эмээл, дөрөө хоёр болно. Энэ нь морины явдал давхиан дунд дайсныг мэргэн харвах боломжийг олгожээ. Монголчууд морины зөв талын дөрөө ялимгүй урт байдаг нь учиртай ажээ. Энэ нь морин дээрээс баруун гараар сэлэмдэх, харвахад тохиромжтойн дээр хурдан түргэн мордох, буухад ч тусална. Богино дөрөө давхиан дунд цэцэн харвах боломж өгдөг нь дайны үед чухал ач холбогдолтой байна.

Энэ бүхнээс үндэслэн олон улсын эрдэмтэд : *"Монголын агт морьд нь Европ болон Азийн бусад орны агт морьдоос байлдааны чадавхи тун дээгүүр байжээ"* (30) гэж академич Н. Ишжамцын дүгнэлттэй санал нэг байгаагаа энд хэлмээр байна.

Монголчууд байлдааны чадавхи сайтай энэхүү адуун сүргээ үй олноор өсгөсөний ачаар түм, түмэн хөнгөн морьт цэргийг жагсаан гаргаж чаддаг бөгөөд Монголын хөнгөн морьт цэргийн чадвар, богино хугацаанд хугацаанд тулааны ашигтай чиглэл, байрлалыг олж чаддаг байсан нь орчин цагийн механикжсан цэргийн техникийн шинжийг агуулж байсан болно.

Энэхүү бяцхан өгүүлэлээ тоймлон дараахь гаргалгааг хийж болмоор байгаа билээ. Үүнд:

- Чингис хааны байгуулсан феодалын хаант улсын армийн хүчин чадал нь дасгал сургуультай агт-морьдын хатуужил тэвчээрт чанар нь Ази, Европ тивийг дамнасан хүчирхэг улсыг байгуулах аян дайны ялалтанд хүргэжээ,

- Монголын морьт цэрэг нь тухайн цаг үеийнхээ хамгийн шилдэг нь байсан бөгөөд Хятад, Ойрхи Дорнод, Европын морьт цэргүүдтэй хийсэн халз тулаалдаань

явцад өөрийнхөө давуулаг чанар, тэсвэр тэвчээрийг **монгол морины хүчээр** баталж чадсан болой,

- Дэлхийн хуурай газрын талыг эрхшээсэн Монголын аугаа эзэнт гүрний үед морь нь холбоо мэдээлэлийг үүргийг ч гүйцэтгэж байлаа. Өөрөөр хэлбэл, Монгол морь дайн тулааны үед эзнийхээ итгэлт нөхөр нь болоод зогсоогүй энх цагийн бүтээн байгуулалтанд эрхт төрдөө зүтгэж, өнөө цагийн дэлхий дахины холбоо харилцааны цахим ситемийн үүргийг гүйцэтгэж байлаа.

- Монгол морьд нь гэнэтийн довтолгооныг түргэн тусгах чадвартай хөнгөн морин цэргийн урлагийг хөгжүүлж чадсан энэ хосгүй чадварыг хойшидоо Төв Ази, Орос болон Европын орнууд морин цэргийн үндсэн сургалтын арга барилд шинэлэг эрч хүчийг бий болгов.

- XIII зууны морь цэргийн арми нь XX зууны дунд үед дэлхийн олон улсыг хамарсан Эх орны хоёрдугаар дайны үеэс морьт армийн бие даасан төрөл цэрэг байхаа болих хүртэл Чингис хаан хийгээд түүний хойч үеийн монголын олон, олон гарамгай жанжидийн цэрэг, дайны үйлд морь нь цэрэг дайны төгөлдөр чанараа алдалгүй үүргээ гүйцэтгэсээр ирсэн билээ.

Abstract: Pastoral animal husbandry is an inherent way of life for the Mongolians since the antiquity; and the horse has been and remains the best companion of a Mongol. It is said that a Mongol is "born, lives and dies on the horseback." Especially it is true for the renowned warrior tradition of the Mongolians, since the horse has ever been an integral part of the warfare.

Ном зүй

1. Л.Мөнхтөр. Монгол адууны зүс, шинж заасан утга зүй, бүтэц.УБ.,2002 тал 10
2. Г.Цэвэгмэд. Монгол адуу. УБ.,2000 тал 26
3. Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг.УБ.,1980 тал 23
4. А.Дамдинсүрэн. Монголын зэвсгийн товч түүхУБ.,1992 тал 66
5. Мөн тэнд.тал 59
6. В.С.Таскин. Скотоводство у сюнню по китайским источникам.//Вопросы истории и историографии Китая//. Москва.,1968 тал 26
7. А.Дамдинсүрэн. Дурьдсан бүтээл. тал 73
8. Монголын Нууц Товчоо / хэв.бэлд.Ц.Дамдинсүрэн /.УБ.,тал 119

9. С.С.Уолкер. Чингис хаан /орч.Б.Даш-Ёндон/.УБ.,2001 тал 23
10. Сампилноров. Монгол зан аалийн тойм. ӨМӨЗО.,1990 тал 214
11. Мөн тэнд.тал 212
12. Х.Шагдар. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх /хоёрдугаар дэвтэр/ УБ., 2001 тал 637
13. Х.Шагдар. Чингис хааны байлдааны цадиг. УБ.,1993 тал.229
14. Лео Де Хартог. Дэлхийг эзэгнэгч Чингис хаан /орч.Ж.Насанжаргал/ УБ., 2004 тал 83
15. Юань улсын түүх. УТНС /гар бичмэлийн сан/
16. Х.Шагдар. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх /хоёрдугаар дэвтэр/ УБ., 2001 тал 503
17. Ж.Гэрэлбадрах. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ.,2002 тал 198
18. Г.Цэвэгмэд. Монгол адуу. УБ., 2000 тал 29
19. С.С.Уолкер. Чингис хаан /орч.Б.Даш-Ёндон/ УБ., 2001 тал 18
20. Ж.Базарсүрэн. Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ., 2000 тал 41
21. Л.Мөнхтөр. Дурьдсан бүтээл. тал 17
22. Монголын Нууц Товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга тайлбар /оршил, тайлбар хийсэн акад.Д.Цэрэнсодном/. УБ.,1999 тал 127
23. Сайшаал. Чингис хаан товчоон. ӨМӨЗО., 1987 тал 420
24. С.С.Уолкер. Дурьдсан бүтээл. тал 24
25. Ж.Ведерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Чингис хаан /орч.А.Мөнгөнзул/. УБ., 2005 тал 84
26. Ж.Базарсүрэн. Дурьдсан бүтээл. тал 26
27. Сюй Да Хень. Монголын зан суртахуун. ӨМӨЗО.,1982 тал 132
28. С.С.Уолкер. Дурьдсан бүтээл. тал 25
29. Сүн Лянь Дай Юань улсын бичиг. ӨМӨЗО.,1987 тал 179
30. Н.Ишжамц. Чингис хаан хятадын эрдэмтэн Чан Чун Бомбыг урьж уулзсан нь. //Өрнө Дорно сэтгүүл № 02 // УБ.,1993 тал 86